# МОНГОЛ УЛС
# БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 11 өдөр Дугаар А/378 Номгон

Иргэн Х.Цэрмаагийн эзэмшил газрын
зөрчил арилгах тухай

Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн "Газрын харилцааны талаар авах арга хэмжээний тухай" 135 дугаар тогтоолын 1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэн Х.Цэрмаагийн нийтийн орон сууцны зориулалттай 1000 м2 газрын талбайн хэмжээ зөрүүтэй байгаа тул зөрчлийг арилган илүү эзэмшиж буй 20м2 газрын үнийг төлүүлэн нэмж эзэмшүүлж хавсралтаар баталсугай.

2.Газрын талбайн хэмжээ өөрчлөгдсөнтэй холбогдуулан эзэмшил газрыг улсын бүртгэлд бүртгэн гэрчилгээ олгож, гэрээний биелэлтийг жил бүр дүгнэн ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл), эзэмшил газарт Улсын бүртгэлийн "Э" дугаар олгохыг Улсын бүртгэлийн хэлтэс (Ц.Мөнхжаргал) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Эзэмшил газрыг зориулалтын дагуу зүй зохистой ашиглаж цаашид дээрх зөрчлийг гаргахгүй байхыг иргэн Х.Цэрмаад үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

ДАРГА Д.МӨНХСАЙХАН

621010951

Аймгийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын
11-ний өдрийн А/378 дугаар захирамжийн хавсралт

# ЭЗЭМШИЛ ГАЗРЫН ТАЛБАЙН ХЭМЖЭЭ ӨӨРЧЛӨГДӨЖ БАЙГАА АЖ АХУЙ НЭГЖИЙН МЭДЭЭЛЭЛ

| д/д | Газар эзэмшигчийн нэр | Регистрийн дугаар | Нэгж талбарын дугаар | Зориулалт | Хаяг | Талбайн хэмжээ /м2/ | Залруулгаар нэмэгдэж байгаа талбайн хэмжээ /м2/ | Нийт талбайн хэмжээ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Х.Цэрмаа | ВВ62102105 | 040700233-001 | 5-8 давхар нийтийн орон сууц | Баянхонгор сум, Рашаант 10-р баг, Рашаантын-3 гудамж, 305 тоот | 1000 м2 | 20 м2 | 1020 м2 |

_______oOo_______